



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/478

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, аймгийн Онцгой комиссын 2024 оны 06 сарын 25-ны өдрийн 8 дугаар тэмдэглэл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Булган сумын Рашаант багийн Зүүнтүрүүний голоор авто тээврийн хэрэгсэл зорчих хөдөлгөөнийг хэвийн болгох түр замын засварын ажилд 43,000,000 (дөчин гурван сая) төгрөгөөр “Булган АЗЗА” ТӨХК-тай гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг “Булган АЗЗА” ТӨХК захирал (М.Мөнх-Эрдэм)-д үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4. Дээрх ажлын хөрөнгийг аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд батлагдсан “Байгалийн гамшгийн үеийн авто зам, замын байгууламжийн засвар” зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010619